



## Өдөр тутмын амьдралын дадал

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus  
Vol. 205 (2022.10)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Монголын РКК  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Сүсэгтэн хүмүүс юуны түрүүнд өдөр бүр бурхан тахилынхаа өмнө өглөө, орой судар номоо уншдаг байх хэрэгтэй. Мөн амин өдөр нийгэмлэг дээр очин хоозад суух, цаашлан өөрийн үйлдлээ бурханы сургаалд нийцүүлэхийг хичээгээд ирэхээр амьдрал тэр чигээрээ бурханы зам мөр болоод ирдэг. Зам мөр гэдэг нь үйл хөдлөлийг хэлж буй. Өдөр тутмын амьдралын үйл хөдлөл бүрээ бурханы сургаалын дагуу цэгцлээд явах нь буддын шашинтан хүний зам мөр гэж хэлж болно.

Сургаалыг сурсан төдийд бурханы шашныг мэдчихлээ гэж бодох нь жишээ нь гольфын чадвараа сайжруулах номыг уншаад л гольф тоглодог болсон гэж бодох, зааврыг нь уншаад л хөгжим тоглож чаддаг боллоо гэхтэй адил зүйл юм. Ингэж боддог хүн байхгүй байх гэж бодож байна. Бурханы үйл ч гэсэн үүнтэй адилхан.

Шашин бол мэдлэг олгох бус амьдрах ухааныг дадуулах зорилготой. Эхлээд сургаалыг сурч, дараа нь түүнийх нь дагуу хэрэгжүүлэн өөрийн болгодог. Энэ зам мөрийг дэмжин туслах хүнтэй ойр байхад сургаалыг хэрэгжүүлэхэд хялбар байдаг. Өөрөөр хэлбэл бурханы үйл санга нарын тусламжтайгаар төгс болдог учиртай.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X250-251

## Зовлонгийн үндсийг танин мэдэх нь Бэлгэ билгүүн-1

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Бурханы бэлгэ билгүүнийг хүртэх гэдэг нь

“Тоглож наадах үедээ талбайн жижгийг гайхан тоглодог атлаа өглөөний цэвэрлэгээгээр чулууг нь түүлгэхээр томыг нь гайхан түүнэ.” Би «Сэтгэлээ боловсруулах» хэмээх номондоо ч гэсэн энэ “Спортын талбай” гэдэг шүлгийг танилцуулсан. Зургаан барамидын “билгийн барамид” гэж юу болох талаар бодонгоо бичсэн 4-р ангийн сурагчийн энэ шүлэг нь хэн бүхэнд хамаатай чухал зүйлийг сургадаг. Тиймээс эхлээд энэ шүлгийг сэтгэл оюуныхаа хаа нэгтээ хадгалаад аваарай гэж хүсэх байна.

Буддын “бэлгэ билгүүн” гэдгийг “мөнх бусын зүй тогтлыг гярхай ажиглах хурц ухаан” («Иванами бурханы шашны толь бичиг», Иванами номын дэлгүүр), эсвэл “хоосон чанар гэх мэт буддизмын туйлын үнэн сургаалын дагуу аливаа зүйлийг зөв ухамсарлаж, шийдвэр гаргах чадвар” (зургаан барамидын нэг, *prajna*, «*Daijirin*» Sanseido) гэх мэтчилэн тайлбарладаг. Нэгтгээд хэлбэл “бэлгэ билгүүн” гэдэг нь “мөнх бус ба хоосон чанар гэсэн үнэнийг ухан ойлгох чадвар”, “орчлонгийн зүй тогтол, учир шалтгааныг танин мэдэж, зөв шийдвэр гаргах чадвар” гэсэн утгатай болох байх. Энэхүү их л хэцүү санагдах “бэлгэ билгүүн” гэдэг үг санга (ижил сүсэг бишрэлт номын нөхөд) нар бидний ярианд үе үе хэрэглэгддэг.

Зовлон бэрхшээлийг тань өөрийн зовлон мэт сонсож ойлгодог хэн нэгнээс “бурханы бэлгэ билгүүнийг хүртэхийн төлөө хичээгээрэй”, “бурханы бэлгэ билгүүнийг хүртэх юм бол аз жаргалтай болно оо” гэсэн урам зориг өгөх үгийг сонсож байсан хүн цөөнгүй болов уу.

Гэхдээ ер нь “бэлгэ билгүүн” гэдэг зүйлийг Бурхан өгдөг гэж үү?

Шагжамүни бурханы гэгээрсэн туйлын үнэнийг танин мэдэж, түүнд тулгуурлан аливаа зүйлд хандах гэдэг утгаараа Шагжамүни бурханыг хүндлэн дээдэлж, талархах сэтгэлээр “бурханаас бэлгэ билгүүнийг хүртэх” гэж хэлж ярьдгийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ үнэндээ бэлгэ билгүүнийг Шагжамүни бурхан

өгдөггүй бөгөөд “бидний дотор туйлын үнэнийг ухамсарлан, түүнд тулгуурлан аливаа зүйлд хандах чадвар байдаг” гэдгийг ойлгож, тэр бэлгэ билгүүнээ өдөр тутмын амьдралдаа ашиглах нь бурханы шавь бид бэлгэ билгүүнийг хүртэж байна гэсэн үг болох юм.

## Баригдмал сэтгэлээ удирдаж сурах нь

Ер нь буддизм яагаад бэлгэ билгүүнийг чухалчилж үздэг юм бол? Шагжамүни бурханы сургаалын түүвэр «Сутта Нипата»-д бичсэн дараах шүлгээс “бэлгэ билгүүн”-ий чухлыг бага зэрэг ойлгох болов уу. “Хүсэл шуналаа гүйцэлдүүлэхийг хүсэгч нэгэн хүсэл нь биелэх юм бол хүний туйлын ихээр хүсдэг зүйлийг олж аваад сэтгэлдээ баясна.” Харин “Хүслээ гүйцэлдүүлэхийн шуналд автсан хүн хүсэл нь биелэхгүй бол туйлын ихээр шаналан зовно.” Өөрөөр хэлбэл “Хорвоогийн элдэв зовлон нь баригдмал сэтгэлээс үүсэн бий болдог.” («Буддагийн үг» , орчуулагч Накамүра Гэн, Иванами судар бичгийн хүрээлэн) гэсэн байна.

Хүсэл шунал, баригдмал сэтгэлийг удирдах “бэлгэ билгүүн” байх аваас зовлон аяндаа холдон явдаг учиртай. Дээр хамгийн эхэнд хэлсэн шүлгийг эргэн санацгаая. Нээрэн л бид нэг л адилхан спортын талбай байхад “тоглож байхдаа давчуу байна, жижиг байна” гэж гомдоллодог мөртлөө “чулууг нь түүлгэхээр том байна” гэж мунхаглан аливаа зүйлийг өөрийнхөөрөө байлгахыг хүсдэг ба энэ нь зовлон шаналалыг үүсгэх үндэс болдог ажээ.

Тиймээс Шагжамүни бурхан шунал хүсэл, баригдмал сэтгэлийг удирдах “бэлгэ билгүүн”-ийг олох аргыг ийнхүү заан сургасан байдаг. “Хувиа бодсон сэтгэлдээ баригдах бодлын хүлээсээ тасчин хаяж, хорвоо ертөнц хоосон чанартайг ухаарвал зохилтой.”

“Хоосон чанар” гэхээр бүр л хэцүү санагддаг тул энэ талаар дараагийн дугаараар хамтдаа зах зухаас нь сурья гэж бодож байна. Ерөнхийдөө хоосон чанар гэдэг нь аливаа зүйлийг өөрийн дур зоргоор жижиг байна, том байна гэж үнэлж дүгнэхгүйгээр бодит байдлыг байгаагаар нь хүлээж авахыг хэлнэ.

Ийнхүү олж эзэшсэн “бэлгэ билгүүн”-ээрээ аливаа зүйлд хандан, намрын цэлмэг тэнгэр мэт саруул тунгалаг сэтгэлээр бусдын төлөөх бодисадвагийн үйлийг итгэл дүүрэн хамтдаа хэрэгжүүлцгээе.

*“Косей” сэтгүүл, 10-р сарын дугаар*

# Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

## Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

### Шагжамүни бурханы шилдэг арван шавь - 2

Бүхнийг нэвт харагч гэгддэг Анурудха бол бүхий л зүйлийг харах чадалтай байв. Упали сахилыг бат сахиж, Шагжамүни бурханыг нирваан дүр үзүүлсний дараа болсон “Судрын эмхэтгэлийн чуулган”-д чухал үүрэг гүйцэтгэжээ. Харин Ананда бол бурхан багшид хамгийн ойр дотно үйлчилж асардаг байсан бөгөөд олон номлолыг нь сонсож байсан учраас шилдэг сургаал сонсогч гэж нэрлэгддэг. Шагжамүни бурханы төрсөн хүү Рахула бол сургаалыг чин үнэнчээр хэрэгжүүлдэг байв. Махакашапа бол зудагёо буюу бадар барих хэцүү үйлийг хэрэгжүүлсэн шавь бөгөөд Шагжамүни бурхан түүнд өмсгөлөө бэлэглэж байжээ.

Бүхнийг  
харагч  
Анурудха



Бурханы  
номлолыг  
хамгийн их  
сонссон  
Ананда



Сахилыг  
бат  
сахигч  
Упали



Шагжамүни  
бурханы  
хүү Рахула



Хэцүү үйлийг  
ноорхой  
хувцастайгаар  
хэрэгжүүлсэн  
Махакашапа



#### Бяцхан мэдлэг

“Бүхнийг нэвт харагч” гэдэг нь бодит зүйлийг төдийгүй өнгөрсөн, одоо, ирээдүйг харж чадах ер бусын чадвар юм.

“Шилдэг сургаал сонсогч” гэдэг нь Шагжамүни бурханы сургаалыг маш их сонсож, ойлгосон гэсэн үг болно.



## Ертөнц “Шүтэн барилдлагын хууль”-ын дагуу оршдог



Шагжамүни бурхан өвчин, үхлээс хэрхэн зайлсхийх арга замыг хайн гэрээсээ гаран явж, тасралтгүй зам мөрийг хэрэгжүүлсний үр дүнд гэгээрэлд хүрсэн билээ. Тэрээр “шүтэн барилдлага” гэдэг зүйлийг гэгээрсэн юм.

Шүтэн барилдлага гэдэг нь бүхий л зүйлс тодорхой учир шалтгаанаар, тодорхой нөхцөлтэй учирсны үр дүнд үүсэн бий болдог гэсэн хууль юм.


Жишээлбэл цэцгийн үр ус, хөрс, нарны гэрлийн тохиромжтой нөхцөл бүрэлдсэн үед л соёолдог. Мөн цэцэг дэлгэрсний дараа шавьж

ирж тоос хүртээсэн учраас үр жимс боловсордог.

Эсрэгээрээ нөхцөл нь бүрэлдэхгүй л бол цэцгийн үр соёолохгүй, тоос хүртээхгүй бол үр жимс гарч ирэхгүй.

Үүнтэй адил бид сэтгэлийн түгшүүр, зовлонгийн учир шалтгаан, нөхцлийг арилгаж байж түгшүүр зовлонгоос ангижрах учиртай юм. Шагжамүни бурханы бидэнд сургасан энэхүү “Шүтэн барилдлагын хууль”-ыг зөв ойлгон, сайтар өөрийн болгож авч чадвал ямагт сэтгэл амар амгалан байх болно.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Олон улсын хэлтсийн даргын булан

### Байгаагаар нь хүлээж авах хамгийн чухал

Хэлтсийн даргын булангийн уншигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөгийн завгүй нийгэмд амьдарч байгаа бид энэ хурдтай амьдралын урсгалаас түр зуур ч болов завсарлага авч аливааг тайван бодох цаг гаргах нь чухал. Энэхүү булангаараа та бүхэнд эргэцүүлэн бодох санаа өгч чадвал үүнээс илүү эрхэм зүйл үгүй.

Энэ сарын айлдвараар “Зургаан барамид”-ын сүүлчийн “Билиг барамид”-ыг сурах болно. “Зовлонгийн үндсийг таньж мэдэх нь” гэсэн сэдэв биднийг “зовлонгийн шалтгаан юу вэ” гэсэн асуулт руу хөтөлдөг. Бурханы шашинд “зовлон” гэдэг нь “хэрэг явдал төлөвлөсний дагуу болохгүйн улмаас үүсэх сэтгэлийн төлөв байдал” гэсэн утгыг илэрхийлдэг. Бурханы сургаалыг мэдэхгүй хүн өөрийн хувийн бодол, ая тавандаа нийцүүлэхийн тулд бүхнийг санаснаараа хийх гэж зүтгэдэг. Үүний эцэст бэлгэ билгүүнээс хол, өөрийгөө зовоох үр дагаврыг авчрах нөхцөл байдалд орчихсон байдаг.

Цагаан лянхуа судрын сургаалаас үзвэл “харах” гэдэг ханз нь “байгаагаар нь харах” гэсэн үг бөгөөд “үнэлж дүгнэлгүйгээр харах”, “ямар нэг байр сууринаас дүгнэлгүйгээр харах” гэсэн үг юм гэж Нивано ерөнхийлөгчийн урьд хэлж байсныг санаж байна.


Иймээс зовлонгийн эх үндэс рүү хөтлөх аминч үзлээ таньж, өөрийн дотоод “бэлгэ билгүүн”-ээ ашиглан амьдарцгаая.

Кэйичи Акагава





# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
Email: sangha@rkhawaii.org URL: <https://rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
Email: info@rk-la.org URL: <https://www.rk-la.org>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
(Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA  
TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com  
URL: <https://sf-buddhism.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

## Rissho Kosei-kai of Sacramento

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <https://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
TEL: 1-773-842-5654  
Email: rkchicago@rkchi.org URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

Email: rkftmyersbuddhism@gmail.com URL: <https://rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
(Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
Email: dharmacenter@rkok-dharmacenter.org  
URL: <https://rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA  
TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567  
Email: info@rkina.org  
URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
(Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA  
TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745  
Email: dharmasa@rksabuddhistcenter.org  
URL: <https://rksabuddhistcenter.org>

## Rissho Kosei-kai of Seattle

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com  
URL: <https://www.buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
Email: risho@rkk.org.br URL: <http://rkk.org.br>  
Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>  
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

**在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai**  
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

**在家佛教韓國立正佼成會釜山支部**

**Korean Rissho Kosei-kai of Busan**  
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

**社團法人在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei**  
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

**台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan**  
台灣台南市東區崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

**Rissho Kosei-kai South Asia Division**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

**Rissho Kosei-kai Society of Kolkata**

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

**Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,  
West Bengal, India

**Rissho Kosei-kai of Bodhgaya**

Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,  
Bihar, India

**Rissho Kosei-kai of Patna**

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

**Rissho Kosei-kai of Singapore**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai of Phnom Penh**

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

**Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141

**Rissho Kosei-kai of Bangkok**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 Email: info.thairissho@gmail.com

**Rissho Kosei Dhamma Foundation**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

**Rissho Kosei-kai Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL: 880-2-41360470

**Rissho Kosei-kai Mayani**

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Damdama**

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Satbaria**

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Chendhirpuni**

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai Raozan**

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Laksham**

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

**Rissho Kosei-kai Dhaka North**

Bashundhara R/A, Dhaka, Bangladesh

**Rissho Kosei-kai Cox's Bazar**

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

**Rissho Kosei-kai Patiya**

**Rissho Kosei-kai Ramu**

**Rissho Kosei-kai Aburkhil**

**Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia  
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Erdenet**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Roma

**Rissho Kosei-kai di Venezia**

**Rissho Kosei-kai of Paris**

**Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK  
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>  
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>  
Twitter: [https://twitter.com/rkuk\\_official](https://twitter.com/rkuk_official)  
Instagram: [https://www.instagram.com/rkuk\\_official](https://www.instagram.com/rkuk_official)  
YouTube: [https://www.youtube.com/c/rkuk\\_official](https://www.youtube.com/c/rkuk_official)

**Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)**

〒 166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <https://www.ibt-rk.org>